

Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2017 оны 7 дугаар сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт



I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2017 оны 7 дугаар сард ХХҮГ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 642 болж, 2016 оны мөн үеэс 109 хүнээр, өмнөх сарынхаас 193 хүнээр тус бүр буурлаа.

Ажилгүйчүүдийн 45.5 хувь буюу 292 нь эмэгтэйчүүд юм. 2017 оны эхнээс 539 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 466 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 46.6 хувь буюу 217 нь эмэгтэйчүүд байв. Ажилгүйчүүдийн бүртгэлээс оны эхнээс 2343 иргэн хасагдлаа.

Аймгийн бүртгэлтэй ажилгүйчүүдийн 33.6 хувь нь Зуунмод; 7.6 хувь нь Баянцогт; 6.8 хувь нь Жаргалант; 5.9 хувь нь Цээл; 5.8 хувь нь Баян-Өнжүүл; 4.8 хувь нь Угтаал сумдад бүртгэгджээ.

Тайлант сард бүртгүүлсэн 184 ажилгүй иргэний 32.1 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 18.5 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 6.0 хувь нь цэргээс халагдсан; 5.4 хувь нь шилжин суурьшсан; 3.8 хувь нь мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 3.3 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 2.2 хувь нь одоо эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй; 1.6 хувь нь орон тооны цомхотголд орсон; 2.6 хувь нь тэтгэвэрт гарсан; 1.1 хувь нь тэтгэвэрт гарсан; 0.5 хувь нь байгууллага татан

буугдсан; 25.5 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Ажилгүйчүүдийг боловсролын түвшингөөр хуваавал 16.5% нь дээд; 3.3% нь тусгай дунд; 7.6% нь мэргэжлийн анхан шатны; 59.3% нь бүрэн дунд; 10.1% нь суурь; 2.0% нь бага; 1.1 хувь нь боловсролгүй иргэд юм.

Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд дунджаар 112 ажилгүйчүүд ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 20 хүнээр буурлаа. Аймгийн дундажтай сумдын дунджийг харьцуулбал Баянцогт, Баян-Өнжүүл, Өндөрширээт, Цээл, Зуунмод, Угтаал, Бүрэн, Сүмбэр сумдад аймгийн дунджаас олон ажилгүйчүүд (421-114 хүн) ногдов.

Тайлант сард ажилд зуучлуулсан 47 иргэний 31.9 хувь нь 15-24 насныхан; 34.0 хувь нь 25-34 насныхан; 17.0 хувь нь 35-44 насныхан; 14.9 хувь нь 45-59 насныхан байв.

2017 оны эхний 7 сард ажлын шинэ байранд 560 иргэн ажилд оржээ. Эдийн засгийн салбарын ангилалаар ангилбал 35.0 хувь нь ХАА, ойн аж ахуйн салбарт; 19.3 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн; 14.8 хувь нь уул уурхай, олборлолтын; 11.1 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний; 4.5 хувь нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний; 3.4 хувь нь барилгын; 2.7 хувь нь хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт; 2,1 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагааны; 1.4 хувь нь боловсролын; 1.4 хувь нь удирдлагын

болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа; 1.1 хувь нь усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны; 1.1 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны; 0.7 хувь нь санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны; 0.4 хувь нь мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны; 0.4 хувь нь тээвэр ба агуулахын үйл ажиллагааны; 0.2 хувь нь цахилгаан, хий, уур, агааржуулалт; 0.2 хувь нь урлаг, үзвэр, тоглоом наадмын салбаруудад тус тус ажилд орлоо.



I.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2017 оны эхний 7 сард НДШ-ийн орлого 10.4 тэрбум ₮ болж төлөвлөгөө 109.2 хувь болж, төлөвлөгөөг 24 сум 66.4-0.9 хувиар давуулан биелүүлж, Баянчандмань, Заамар, Батсүмбэр сумд 13.6-4.6 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 664.4 сая ₮ болж төлөвлөгөөг 99.5 хувиар биелж, Зуунмод сум 2.6 хувиар таслав.

Тэтгэвэр, тэтгэмжинд 23.6 тэрбум ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 79.9 хувийг өндөр настны, 10.0 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.7 хувийг тэжээгчээ алдсаны, 5.4 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 282900 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 35.2 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 24.4%; тэтгэмжийн даатгалын сангийн 87.1%;

эрүүл мэндийн даатгалын сангийн 114.9%; үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 128.3%; ажилгүйдлийн даатгалын сангийн 81.1%-ийг тус бүр бүрдүүлжээ.

2017 оны эхний 7 сард нийгмийн даатгалын сангийн авлагын дүн 873,5 сая ₮, өглөгийн дүн 223,6 сая ₮ боллоо.

Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2017 оны эхний 7 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 53512 хүнд олгож, 8.8 тэрбум ₮-ийг зарцуулсан нь 2016 оны мөн үеэс хүний тоо 1.1 хувь 583 хүнээр буурч, зарцуулсан мөнгөний хэмжээ 4.8 хувь 411.4 сая ₮-өөр буурлаа.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 129440 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 47.6 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 18.9 хувийг халамжийн тэтгэвэр; 0.6 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж; 8.3 хувийг насны хишиг; 7.3 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 6.6 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 3.5 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж; 2.1 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид тус бүр зарцуулжээ.




1.3 Эрүүл мэнд

2017 оны эхний 7 сард 9214 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.37 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2017 оны эхний 7 сард 716 хүүхэд мэндэлсэн нь 2016 оны мөн үеэс 25 хүүхдээр буурлаа.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 6 дүгээр сарын байдлаар



Он гарсаар 1 хүртэлх насандаа нас барсан хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 12 хүүхдээр буурлаа.

Зураг 1.4

Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 6 дүгээр сарын байдлаар




2017 оны эхний 7 сард халдварт өвчнөөр 617 хүн өвчилсөн нь өмнөх оноос 43,56 хувь буюу 399 хүнээр буурлаа. Халдварт өвчлөлийг өмнөх онтой харьцуулбал цусан суулга 6 дахин, бусад 67,01 хувь, салхин цэцэг 50 хувь, трихомениаз 44,19 хувь, заг хүйтэн 17,31 хувь тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох халдварт өвчлөл аймгийн дундаж 56 байгаа бол: Зуунмод 180, Баян 79, Аргалант 74, Заамар 55, Баянжаргалан 50 ногдлоо.

Зураг

1.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 6 дүгээр сарын байдлаар



1.4 Байгаль орчин

Төв аймгийн 2017 оны 7 сарын цаг агаарын байдлыг

олон жилийн дундажтай харьцуулсан тойм

-агаарын дундаж температур 17-26 градус дулаан буюу Өндөрширээт орчмоор дулаан, Мөнгөнморьт орчмоор сэрүүвтэр

- өдөр ажиглагдсан агаарын хамгийн их температур нь 32-40 градус дулаан, нутгийн зүүн хойд хэсгээр буюу Мөнгөнморьт, Эрдэнэд 32-34 градус дулаан, бүх нутгаар 32 градусыг давж

халсан ба Өндөрширээт, Борнуурт 40 градус хүрч халсан.

-шөнийн хугацаанд ажиглагдсан хамгийн бага температур нь 4-13 градус дулаан буюу нутгийн баруун хэсгээр дулаавтар, Лүн, Угтаал, Заамар, Өндөрширээт, Баянцагаан орчмоор 10-13 градус дулаан, нутгийн хойд болон зүүн хэсгээр сэрүүвтэр, үүнээс Мөнгөнморьт орчмоор 4 градус дулаан.

- Сарын нийлбэр тунадас 10.3-121.9 мм, Нутгийн зүүн хэсгээр ахиу хамгийн их нь Мөнгөнморьт орчмоор 121.9 мм, Эрдэнэд 79.4 мм, Баянжаргаланд 66,8 мм, Мааньтад 64.5 мм бороо, түр зуурын дуу цахилгаантай бороо оржээ. Хамгийн бага нь Лүнд 10.2 мм, Бүрэнд 10.3 мм бороо орсон байв.

Салхи ихэнх хугацаанд баруунаас 4-9 м/с, борооны өмнө зарим газраар 14-16 м/с, зарим газраар 18-20 м/с, түр зуур 21-23 м/с хүрч нөөлөг салхи ажиглагдсан байна.

Олон жилийн дундажтай харьцуулсан дүгнэлт

Цаг агаарын үзүүлэлтүүдийг 2016 оны 7-р сартай харьцуулахад:

-агаарын дундаж температур нь өмнөх оныхоос ихэнх нутгаар 1-2 градусаар дулаан, зарим газраар ойролцоо, нутгийн зүүн хэсгээр 1-2 градусаар сэрүүн

-өдрийн хамгийн их температур нь ихэнх нутгаар 1-6 градусаар дулаан, зарим газраар ойролцоо

-шөнийн хамгийн бага температур нь зарим нутгаар ойролцоо буюу нутгийн зүүн хэсгээр зонхилон 1-3 градусаар дулаан, бусад нутгаар 1-2 градусаар сэрүүн

-сум тус бүрээр хур тунадасны нийлбэрийг гаргаж үзэхэд ихэнх нутгаар өмнөх оны 7-р сараас бага, нутгийн зүүн хэсгээр ахиу бороо оржээ.

2017 оны 7-р сард тунадасны зонхилох хувь нь 1-р 10 хоногийн эхэн, 2-р 10 хоногийн дунд, 3-р 10 хоногийн сүүлчээр орж, салхи шуурга багатай, цаг агаар харьцангуй тогтвортой, 1-р 10 хоногийн эхэн, 2-р 10 хоногийн дунд хүртэл, 3-р 10 хоногийн сүүлчийн өдрүүдэд 32 градусыг давж, зарим өдрүүдэд нь ихэнх нутгаар 33-40 градус хүрч халалттай хоногууд үргэлжилж, таримал болон бэлчээрийн ургамлын ургалтанд сөргөөр нөлөөлж, гандах нөхцөл бүрдлээ.

Халалт ихтэй, хур бороо ихэнх нутгаар бага орсон нь ургамлын өндөр 6-19 см байв. Сарын сүүлчээр өдөртөө 32-39 градус хүрч халалттай хоногууд үргэлжилж, таримал болон бэлчээрийн ургамлын ургалтанд сөргөөр нөлөөлж, гандах нөхцөл бүрдлээ. Ургамлын өндөр 2-10 см, 2016 оныхоос 2-13 см-ээр бага байна.

2017 ОНЫ НАЙМДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Төв аймгийн нутгаар. Энэ сарын агаарын температурын дундаж нь Төв аймгийн нутгаар 16-21 градус дулаан буюу нийт нутгаар дунджаас 0.5-1.5 градусаар дулаан байна.

Халах үе: Нэгдүгээр арав хоногийн эхээр Туул голын хөндийгөөр шөнөдөө 15-20 градус, өдөртөө 29-34 градус, бусад нутгаар шөнөдөө 11-16 градус, өдөртөө 26-31 градус хүрч хална.

Бага зэрэг сэрүүсэх үе: Нэгдүгээр арав хоногийн дунд үе болон эцэс, хоёрдугаар арав хоногийн эхэн ба дунд үеэр уулархаг нутгаар шөнөдөө 3-8 градус өдөртөө 15-20 градус, бусад нутгаар

шөнөдөө 8-13 градус өдөртөө 19-24 градус дулаан байна.

Сэрүүсэх үе: Гуравдугаар арав хоногийн эхээр ба сүүлчээр сэрүүсч, уулархаг нутгаар шөнөдөө 3 градус дулаанаас 2 градус хүйтэн, хөрсөн дээр 1-6 градус хүрч цочир хүйтэрнэ, өдөртөө 10-15 градус, бусад нутгаар шөнөдөө 5-10 градус, өдөртөө 15-20 градус дулаан байна.

Бусад хугацаанд: Уулархаг нутгаар шөнөдөө 6-11 градус, өдөртөө 19-24 градус, бусад нутгаар шөнөдөө 10-15 градус, өдөртөө 23-28 градус дулаан байна.

Энэ сард Төв аймгийн зүүн хэсгээр уур амьсгалын дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим бороо орох төлөвтэй.

Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр нутгийн зарим газраар, нэг ба хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр ихэнх нутгаар, гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар бороо орно. Дуу цахилгаантай. Борооны өмнө салхи түр зуур ширүүснэ, ялангуяа нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлч, хоёр ба гуравдугаар арав хоногийн эхээр зарим газраар түр зуур 14-16 м/с хүрч ширүүснэ.




1.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2017 оны эхний 7 сард аймгийн хэмжээнд 509 гэмт хэрэг бүртгэгдэж 360 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 2189.2 сая₮-ийн хохирол учирлаа.

Зураг 1.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 7 дүгээр сарын байдлаар



Зураг 1.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 7 дүгээр сарын байдлаар



Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2017 оны эхний 7 сард аймгийн хэмжээнд 509 гэмт хэрэг бүртгэгдэж 360 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 2189.2 сая₮-ийн хохирол учирлаа.

Гарсан гэмт хэргийн 27.7 хувь нь хулгай, 17.8 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний хэрэг, 41.9 хувь нь бусад хэрэг, 8.0 хувь нь замын осол, 3.8 хувь нь танхай дээрэм, 0.8 хувь нь хүн амины хэрэг тус бүр эзлэв. Аргалант, Баянжаргалан, Баянхангай, Сэргэлэн, Өндөрширээт, Заамар, Эрдэнэ, Баян, Алтанбулаг сумдад 10000 хүнд 294-89 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (79)-аас харьцангуй их байна.

Гэмт хэргийн тоо 2016 оны мөн үеэс 16 хэргээр өслөө.

Зуунмод суманд 27 эмэгтэй, 578 эрэгтэй нийт 605 хүн эрүүлжүүлэгдсэн байна.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2017 оны эхний 7 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 764 гүйцэтгэх хуудсанд нийт 5.34 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс биелүүлбэл зохих 33 гүйцэтгэх хуудасны 811.4 сая ₮-өөс 731 хуудасны 4.53 тэрбум ₮-өөс 318 хуудасны 836.5 сая ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 43.50, үнийн дүнгээр 18.45 хувь болж 2016 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 4.15 нэгжээр өсч, үнийн дүнгийн биелэлт 1.54 нэгжээр тус тус өслөө.

Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, зээл, хадгалам

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбаруудын дүнгээр 2017 оны эхний 7 сард кассын орлого 299.2 тэрбум ₮, кассын зарлага 299.9 тэрбум ₮ болж, гүйлгээнд 217.7 тэрбум ₮ байна. ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбарын нийт зээлийн багц зээлдэгчийн тоо 112928 зээлийн багцын дүн 419.5 тэрбум ₮, зээл авсан зээлдэгчийн тоо 47594 олгосон зээлийн дүн 100.1 тэрбум ₮ боллоо. Иргэдийн хувийн хадгаламжинд 7 сарын 31-ний байдлаар хугацаатай хадгаламж 40.9 тэрбум ₮, хугацаагүй хадгаламж 15.3 тэрбум ₮ байна. Иргэдийн харилцах дансны үлдэгдэл 7 сарын 31-ны

байдлаар 196378 иргэний 11.44 тэрбум ₮ боллоо. ХААН, Төрийн, Хас, Капитал банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 1.28-1.48 хувь, хугацаатай доод хүү 0.70-0.80 хувь, хугацаагүй дээд хүү 0.08-0.60 хувь, хугацаагүй доод хүү 0.60-0.63 хувьтай байна.



II.2 Төсөв, мөнгө

Төсвийн орлого 2017 оны эхний 7 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 8.1 тэрбум ₮, зарлага 41.5 тэрбум ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 123.83 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас; Хувь хүний орлогын албан татвар, бууны албан татвар, ойгоос түлээ, мод ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, нохойн албан татвар, бусад төлбөр, хураамжийн төлөвлөгөө биелэгдсэнгүй.

Аймгийн төсвийн орлого 2016 оны мөн үеэс 33.4 хувь буюу 2.0 тэрбум ₮-өөр өслөө. Аймгийн төсвийн орлогын 86.7 хувийг татварын, 12.5 хувийг татварын бус орлого, 0.7 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2016 оны мөн үеэс татварын орлого 1.2 нэгжээр буурч, татварын бус орлого 0.9 нэгжээр, хөрөнгө борлуулсны орлого 0.2 нэгжээр тус бүр өслөө.

Аймгийн нийт 3 шатны орлого 12.8 тэрбум ₮ болж аймгийнх 6.1 тэрбум ₮ буюу 47.58 хувь, сумынх 1.9 тэрбум ₮ буюу 14.84 хувь, улсынх 4.8 тэрбум ₮ буюу 37.58 хувийг тус бүр бүрдүүлжээ.

2016 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 2.5 дахин буюу 820.2 сая ₮-өөр буурч 333.1 сая ₮ болж, авлага 52.9 хувь буюу 48.3 сая ₮-өөр өсч 139.6 сая ₮ боллоо.

Орон нутгийн төсвийн орлого 6.7 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 108.39 хувиар биелэгдэж. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 1.9 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 164.75 хувь биелж, Баянцагаан, Эрдэнэ сумд 4.76-4.64 хувиар тасалдууллаа.

Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 6.1 тэрбум ₮ болж 114.93 хувь биелж Алтанбулаг, Баянцагаан, Баянхангай, Эрдэнэ, Баяндэлгэр, Угтаал, Баянжаргалан, Эрдэнэсант, Дэлгэрхаан, Жаргалант, Зуунмод, Сүмбэр, Архуст сумд төлөвлөгөө 42.17-0.97 хувиар тасалдууллаа.



II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2017 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 3.66 хувиар өсөхөд бусад бараа, үйлчилгээ үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 7.5 хувь; хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 7.0 хувь; тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 6.8 хувь; эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.4 хувь; гэр ахуйн тавилга, барааны бүлгийн үнэ дүнгээрээ 3.4 хувь; хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 3.3 хувь; амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.1 хувь; зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.1

хувь; согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн үнэ дүнгээрээ 1.5 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны эцсээс 3.09 хувиар өсөхөд тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 6.9 хувь; хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 6.8 хувь; эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.4 хувь; хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 3.6 хувь; амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.1 хувь; бусад бараа, үйлчилгээ үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.0 хувь; гэр ахуйн тавилга, барааны бүлгийн үнэ дүнгээрээ 1.0 хувь өссөн нь голлон нөлөөллөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2017 оны 7 дугаар сард өмнөх сараас 0.03 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 0.4 хувь; гэр ахуйн тавилга, барааны бүлгийн үнэ дүнгээрээ 0.05 хувиар буурсан нь голлон нөлөөллөө.

2017 оны 7 дугаар сард өмнөх сараас хэрэглээний сагсны 238 нэрийн бараа, үйлчилгээний

6.7 хувийнх нь үнэ өсөж, 5.0 хувийнх нь үнэ буурч, 88.2 хувийнх нь үнэ тогтвортой байв.



II.5 Аж үйлдвэр


Өмчийн бүх төрлийн аж үйлдвэрийн газрууд 2017 оны эхний 7 сард (2010 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 45,6 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2016 оны мөн үеэс 1.7 дахин буюу 28.9 тэрбум ₮-өөр өслөө. Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний

хувийн жингээс үзэхэд Заамар, Жаргалант, Зуунмод, Баянчандмань, Баянцагаан, Баянцогт, Эрдэнэ, Батсүмбэр сумд 67.51-0.37 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 98.56) хувийг эзлэв.

Оны эхний 7 сарын нийт үйлдвэрлэлтэнд дулааны эрчим хүч 8.47, боловсруулах үйлдвэрлэл 8.38, ашигт малтмал олборлолт 83.15 хувийг тус тус эзлэв.

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь ашигт малтмал олборлолт, сүү, сүүн бүтээгдэхүүн, үр тарианы гурил, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, ус ундаа үйлдвэрлэл, малын тэжээл, нийтлэх хэвлэх дуу бичлэгийн үйл ажиллагаа, нэхмэлийн үйлдвэрлэл, хувцас үйлдвэрлэл, төмрийн үйлдвэрлэл, дулаан, ус хариутгал хангамж үйлдвэрлэл өмнөх оноос 21.8 дахинаас 20.1 хувь буюу 23.1 тэрбумаас- 0.31 сая ₮-өөр өссөн нь нөлөөлөв.

Зураг II.7 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар, хувиар




II.7 Холбоо

Холбоо ашиглалтын орлого оны эхний 7 сард 205.7 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 38.2 сая ₮ болж, нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 96.60 хувь буюу 101.1сая ₮-өөр өслөө.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 53.5 сая ₮ болсон ба нийт орлогын 76.5 хувь нь хүн амд үйлчилсний орлого байна. Нийт орлогын 23.53 хувийг албан бичгийн 9.34 хувийг зорчигчдын, 67.13 хувийг бусад орлого бүрдүүлээ

Зураг II.10

Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 7 дүгээр сарын байдлаар, мянган төгрөгөөр



Стандартчилал хэмжилзүй

Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн 2017 оны эхний 7 сарын мэдээгээр нийт 220 аж ахуй нэгж, иргэнд стандартын салбар сангийн үйлчилгээ үзүүлснээс тохирлын баталгаажуулалт 295, үүнээс тохирлын гэрчилгээ 250; хэмжих хэрэгслийн баталгаажуулалт 3564; цулын хэмжүүр 628, үүнээс жин 538, туухай 84, автомашины жин 6; эзэлхүүн зарцуулалтын хэмжүүр 1383, үүнээс түгээгүүрийн хошуу 220, мерник 5, сүмбэн метр 26, уртын хэмжих хэрэгсэл 8, усны тоолуур 1114; цахилгаан хэмжүүр 1553, үүнээс нэг фазын тоолуур 1553-ыг тус бүр баталгаажууллаа.

барагдуулалт 42.6 сая ₮ болж 47.99 хувьтай байгаа нь 2016 оны мөн үеэс 0.34 пунктээр өслөө.

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2017 оны эхний 7 сард нийт 7200 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд бүртгэл хийснээс үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл 309; төрөөс үнэгүй хувьчилсан орон сууцны баталгаажуулалт 4; төрөөс үнэгүй өмчлүүлсэн газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 2122; газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл 25; бэлэглэлийн гэрээ 179; худалдах, худалдан авах гэрээ 420; өв залгамжлал 115; барьцааны гэрээ 1797; бусад бүртгэл 2254-ийг тус бүр бүртгүүллээ.

Санхүүгийн хяналт, шалгалт

Санхүүгийн хяналт, аудитын алба 2017 оны эхний 7 сард 68 нэгж байгууллагад хяналт, шалгалт хийж 565.3 сая ₮-ийн зөрчил, төлбөр илэрч төлүүлвэл зохих төлбөрийн